



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 11 сарын 07 өдрийн
24/11 тоот тогтоолоор батлав. Хавсралт №5

“БУМАНДУСАЛ ББСБ” ХХК—НЫ ЭРСДЭЛ УДИРДЛАГЫН БОДЛОГО

БУМАНДУСАЛ ББСБ”ХХКОМПАНИЙ ЭРСДЭЛ УДИРДЛАГЫН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү бодлого нь “Буман дусал ББСБ” ХХК-ийн эрмдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, биенесийн үндсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг ханган ажиллах үр дүнтэй, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэхэд чиглэнэ.
- 1.2 “Буман дусал ББСБ” нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлан эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд хамгаалалтын бүсүүдийг чиг үүрэг, хариуцлагыг эрсдэлийн төрөл бүрээр тодорхойлсон байна.
- 1.3 “Буман дусал ББСБ”-ын удирдах эрсдэлийн төрлүүд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журмуудыг ТУЗ-н хурлаар батлуулж Гүйцэтгэх захиралын хэрэгжүүлэх ба тэдгээр нь энэхүү бодлогын салшгүй хэсэг байна.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН СОЁЛ

- 2.1 ББСБ-ын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлын чиг үүрэг, эрх хэмжээ, хариуцлагын хүрээнд эрсдэлийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, үнэлэх, тайлагнах үүрэгтэй.
- 2.2 ББСБ-ын удирдлагууд нь эрсдэлийн соёлыг бий болгох, түгээх, ажилтнуудад эрсдэлийн талаарх ойлголт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх соёлыг бий болгох зорилгоор өөрийн хариуцсан нэгжийг бодлого, журам заавар, мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулна.

ГУРАВ. ХАМГААЛАЛТЫН БҮСҮҮД

- 3.1 ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлах ба тэдгээр нь дараах чиг, үүргүүдтэй байна. Үүнд:
 - 3.1.1 **Хамгаалалтын нэгдүгээр бүс**- Бизнес болон түүнд дэмжлэг үзүүлэгч нэгжүүд байх бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллана. Өөрөөр хэлбэл өөрийн хариуцаж буй үйл ажиллагаа, бизнесийн эрсдэлийг хариуцан ажиллах бөгөөд эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах, бууруулж ажиллах чиг үүрэгтэй байна.
 - 3.1.2 **Хамгаалалтын хоёрдугаар бүс**- Хууль, Эрсдэлийн удирдлагын хэлтэс, эсвэл эрсдэл хариуцсан ажилтантай байх бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана. Өөрөөр хэлбэл эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, журам зааврыг боловсруулах, шинэчлэх, эрсдэлийн лимитийг тогтоох хянах, түүнд мониторинг хийх бөгөөд хамгаалалтын 1-р бүсэд чиглэл, зөвлөмж өгнө.
 - 3.1.3 **Хамгаалалтын гуравдугаар бүс**- Дотоод аудитын хэлтэс, дотоод аудит хариуцсан ажилтантай байна. Дотоод аудитын хэлтэс, дотоод аудит хариуцсан ажилтан нь Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус баталгаажуулалтыг өгөх ба

ингэхдээ Хамгаалалтын 1 болон 2-р бүсийн эрсдэлийг удирдах үйл ажиллагааны үр дүнтэй байдалд хараат бусаар үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

- 4.1 ББСБ-д учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилна. Үүнд:
 - 4.1.1 Зээлийн эрсдэл: Зээлдэгч гэрээгээр хүлээсэх үүргээ биелүүлж чадахгүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал
 - 4.2.1 Зээлийн төвлөрлийн эрсдэл: Нэг болон харилцан хамааралтай зээлдэгч эсвэл нэг салбарт зээлийн төвлөрүүлж олгосны улмаас үүсэх эрсдэл.
 - 4.3.1 Өөрийн хөрөнгийн эрсдэл: Өөрийн хөрөнгийн хүрэлцээ байхгүйгээс бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадваргүй болох, эсвэл зохицуулагч байгууллагын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж чадахгүй болох.
 - 4.4.1 Зах зээлийн эрсдэл: Зах зээл, элийн засгиын хямрал, ханш, хүү инфляцын огцом өөрчлөлөөс үүдэн орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй алдагдал
 - 4.5.1 Хөрвөх чадварын эрсдэл: Өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх чадваргүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдлаас хүлээж болзошгүй алдагдал
 - 4.6.1 Үйл ажиллагааны эрсдэл: Дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагааг хангалтгүй доголдолтой, эсвэл гаднын хүчин зүйлсийн улмаас үүсэх гарз хохирол болон алдагдал.
 - 4.7.1 Аюулгүй байдлын эрсдэл: Бодит болон мэдээллийн аюулгүй байдал алдагах, мэдээллийн системд халдлага хийх эсвэл түүнийг зөрчсөний улмаас үүсэх гарз хохирол болон адагдал.
 - 4.8.1 Ёс зүйн эрсдэл: Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсвэл харилцагчтай шударга харилцах зарчмыг хэрэгжүүлээгүй улмаас гарч болзошгүй алдагдал.
 - 4.9.1 Хянан нийцүүлэлтийн эрсдэл: Хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн стандарт, байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчилдсөнөөс үүдэн нэр хүндээ алдах, тусгай зөвшөөрөл, лицензээ хураалах, торгууль, акт тавиулах, санхүүгийн хувьд үүсэх алдаглыг хэлнэ. Мөнгө угаах болон терроизмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлээгүйгээс үүдэн гарах эрсдэл мөн үүнд хамаарна.
 - 4.10.1 Нэр хүндийн эрсдэл: Олон нийтийн сөрөг ойлголтоос үүдэн байгууллагын нэр хүндэд хохирол учрах, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэл.
 - 4.11.1 Стратегийн эрсдэл: нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн шийдлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн боломжоо алдах, алдагдал хүлээх эрсдэл.
- 4.2 Хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүсүүд дараах байдлаар эрсдэлийн төрлүүдэд хувиарлагдана.

Эрсдэлийн төрөл	Хамгаалалтын 1 бүс	Хамгаалалтын 2 бүс
Зээлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирлагын нэгж
Зээлийн төвлөрлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирлагын нэгж
Зах зээлийн эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирлагын нэгж
Өөрийн хөрөнгөгийн эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирлагын нэгж
Хөрвөх чадварын эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирлагын нэгж
Үйл ажиллагааны эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Аюулгүй байдлын эрсдэл	Бүх нэгжүүд	Мэдээллийн болон бодит аюулгүй байдал хариуцсан нэгж
Ёс зүйн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Нэр хүндийн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Стратегийн эрсдэл	Бүх нэгжүүд	Төлөөлөн удирдах зөвлөл

ТАВ. ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

5.1 ББСБ-ын эрсдэлийг дараах байдлаар бүрдэнэ.

- 5.1.1 Хамгаалалтын гурван бүс буюу эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.
- 5.2.1 Засаглалын бичиг баримтууд буюу эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэлүүдийг удирдах ерөнхий журмууд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журам, стандарт болон зааврууд
- 5.3.1 Засаглалын хороод буюу ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод.

ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

- 6.1 ББСБ нь хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын тавьсан хязгаар үзүүлэлтүүд, бизнесийн болон стратеги зорилтын хүрээнд хүлээж

болох эрсдэл, тэдгээрийн удирдах хэм хэмжээнд тулгуурлан эрсдэлийн төрөл бүрээр ялгаатай тогтоож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллана.

ДОЛОО. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАЛТ

- 7.1 ББСБ нь бүхий л үйл ажиллагаандаа хяналтын тогтолцоог бий болгож, учирч болзошгүй эсвэл гэнэтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорих бөгөөд болзошгүй эрсдэлийг тодорхойлох, тэдгээрийг цаг алдалгүй удирдах зорилгоор эрсдэлийн үнэлгээ болон дүн шинжилгээг хийдэг байна.

НАЙМ. НЭР ХҮНДИЙН БОЛОН СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ

- 8.1 Нэр хүндийн эрсдэл – Байгууллагын нэр хүндэд хохирол учруулж, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэлийг хэлэх бөгөөд ажилтан бүр ёс зүйн дүрмийг чандлан баримталж, харилцагчтай харилцах харилцаа, үйлдэл, мэдлэг чавдар, үйл ажиллагаагаар ББСБ-ын нэр хүндийг хамгаалах үүрэгтэй.
- 8.1.1 Хамгаалалтын нэгдүгээр бүс буюу Бизнесийн нэгжүүд Гүйцэтгэх удирдлага болон салбар нэгжийн удирдлагууд нь ажилтнууддаа ББСБ-ын нэр хүнд, үнэ цэнийн талаарх ойлголт мэдээллийг өгөх, нэр хүндийн эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт мэдээллийг тогтмол өгөх үүрэгтэй. ББСБ-ын ажилтан бүр ББСБ-ын бизнес, үйл ажиллагаа, нэр хүндэд халдсан эсвэл учирч болзошгүй аюул занал байгааг илрүүлсэн, мэдсэн даруй өөрийн удирдлагад эсвэл Хууль, Эрсдэлийн удирлагын хэлтэс, ажилтанд Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үүрэгтэй ба ингэснээр тухайн эрсдэлээс цаг алдалгүй сэргийлэх, бууруулах ач холбогдолтой.
- 8.2.1 Хамгаалалтын хоёрдугаар бүс буюу Хууль, Эрсдэлийн удирдлагын хэлтэс, ажилтан Эрсдэлийн удирдлага хариуцсан хэлтэс эсвэл ажилтан нь ББСБ-ын нэр хүндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, холбогдох хэлтэс нэгжүүдтэй хамтран дэмжин ажиллана. Үйл ажиллагаанаас үүдэлтэй нэр хүндийн эрсдэлийг үнэлэх, хянах процессыг ББСБ-ын үйл ажиллагааны уяалдуулан зохицуулна.
- 8.3.1 Хамгаалалтын гуравдугаар бүс буюу Дотоод аудитын хэлтэс эсвэл ажилтан Хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүсийн нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаанд хараат бус баталгаажуулалтыг хийнэ.
- 8.2 Стратегийн эрсдэл – Байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнесийн шийдлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн боломжоо алдах, алдагдал хүлээх эрсдэлтийг хэлнэ.
- 8.2.1 Хамгаалалтын нэгдүгээр бүс буюу ББСБ-ын Гүйцэтгэх захирал Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын эрхэм зорилго, үнэт зүйлс, алсын харааны хүрээнд ББСБ-ын орлогын эх үүсвэрт эерэг, ашигтай байх бизнес төлөвлөгөө болон холбогдох шийдвэрийг гаргана. Гэвч эдийн засгийн болон зохицуулагч байгууллагын эсвэл

- өрсөлдөөний зэрэг сөрөг нөлөөллүүд нь алдагдалд хүргэх болзошгүй байдаг тул стратегийн эрсдлийг бүрэн бууруулах боломжгүй юм.
- 8.2.2 Хамгаалалтын хоёрдугаар бүс буюу ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөл Стратегийн голлох шийдвэрийг хянан үзэх, сорих, батлах, Стратегийн үндсэн шийдвэрүүд болон шийдвэр гаргах үйл явцын талаах Гүйцэтгэх захирал болон удирдлагын багт санал, зөвлөмж өгөх нв Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг байна.
- 8.2.3 Хамгаалалтын гуравдугаар бүс буюу Дотоод аудитын хэлтэс эсвэл ажилтан Дотоод аудитын хэлтэс эсвэл ажилтан нь стратегийн шийдвэр гаргах процесс болон стандартад хараа бус баталгаажуулалтыг хийнэ.

—ooOoo—